



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 400

Улаанбаатар хот

**Удирдамж болгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.1.3 дахь заалт, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 8.2в, 8.3а дахь хэсэг, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01/3382 дугаартай албан тоотыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1. “Эрдэнэсант АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Дамдинжавын Баатарыг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцлах асуудлыг шийдвэрлэх.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ